



ХЭНТИЙ АЙМГИЙН  
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 03 сарын 09 өдөр

Дугаар А/11

Мөрөн сум

Г.Дашмаад 5 жил тутамд нэг удаа олгодог  
мөнгөн урамшуулал олгох тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3, Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 83 дугаар тогтоолын 2.1, 2.3, 4.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Мөрөн сумын Засаг даргын тамгын газрын Төрийн сангийн мэргэжилтэн (Г.Дашмаа) нь Төрийн захиргааны албан тушаалд тасралтгүй тогтвор, суурьшилтай ажиллаж байгаа тул Төрийн захиргааны албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох журмын дагуу мөнгөн урамшуулал олгосугай.

2.(Г.Дашмаа)-д олгох мөнгөн урамшуулал 8 394 000 (найман сая гурван зуун ерэн дөрвөн мянга)-н төгрөгийг Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны мөнгөн урамшуулал олгох зардлаас олгохыг Нягтлан бодогч (Б.Нандин-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү албаны дарга (Ц.Болорцэцэг)-д даалгасугай.

ДАРГА



Н.НАМЖИЛНОРОВ